



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/42

Шивээговь сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 31 дүгээр зүйлийн 31.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2020 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд “Хөшөө дурсгал” барих зориулалтаар батлагдсан 0,09 га газрыг төрийн өмчит Шивээ-Овоо хувьцаат компанид 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Өөрийн хөрөнгөөр тухайн газрыг цэвэрлэж, тохижуулж, Хөшөө дурсгал барьж тухайн газрыг зориулалтын дагуу ашиглаж, Монгол Улсын Газрын тухай хууль, тогтоомжийг дагаж мөрдөхийг Шивээ-Овоо хувьцаат компанид үүрэг болгосугай.

3. Газар эзэмшигч Шивээ-Овоо хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшинтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Э.Баярмагнай/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ